

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх



Гэрчлэл болон ХӨРВӨЛТ

Үнэний талаарх гэрчлэл хүлээн авах болон жинхэнэ хөрвөгдөх хоёрын хооронд ялгаа бий. Жишээ нь, агуу төлөөлөгч Петр Есүс бол Бурханы Хүү гэдгийг мэднэ гэсэн гэрчлэлээ Аврагчид хэлсэн.

“[Есүс] тэдэнд, “Та нар намайг хэн гэж хэлэх вэ?” гэсэнд, “Симон Петр: “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн гэв””.

“Есүс түүнд хариуд нь, Бариона Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин Тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм гэжээ (Матай 16:14-17).”

Гэсэн ч үүний дараа Их Эзэн Петр өгсөн тушаалуудаа түүнд болон бидэнд зориулан хэрхэн жинхэнэ хөрвөгдөж, мөн тэр хөрвөлтөө амьдралынхаа туршид үргэлжлүүлэх зааврыг өгсөн. Есүс үүнийг, “Та нар хөрвөгдөх үедээ ах дүүсээ батжуул” хэмээн хэлсэн байдаг (Лук 22:32).

Есүс Христийн жинхэнэ хөрвөгдсөн шавь нарын адил бодож, мэдэрч, үйлдэхийн тулд гэрчлэлтэй байхаас гадна ихээхэн өөрчлөлт хийгдсэн байх ёстой болохыг Есүс Петр заасан байдаг. Энэ нь бидний эрэлхийлж буй тэрхүү агуу том өөрчлөлт юм. Өөрчлөлтийг хүлээн авсныхаа дараа бид тэрхүү өөрчлөлтөө мөнх бус амьдралынхаа сорилтыг дуустал үргэлжлүүлэх ёстой (Алма 5:13-14-ийг үзнэ үү).

Бид өөрсдийн туршлага болон бусдыг ажигласны үндсэн дээр сүнслэг хүчийг мэдэрсэн хэдэн агуу агшин

бидний амьдралын турш тууштай байхад хангалтгүй болохыг мэднэ. Есүс бол Христ хэмээх гэрчлэлийг Сүнсээр хүлээн авсныхаа дараа ч гэсэн Петр Аврагчийг мэддэг болохоо үгүйсгэсэн. Мормоны Номын гурван гэрч Мормоны Ном бол Бурханы үг хэмээх гэрчлэлээ биечлэн хүлээн авсан ч, дараа нь тэд Иосеф Смитийг Их Эзэний Сүмийн бошиглогч гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй тээнэгэлзэж байсан билээ.

Бидэнд Алмагийн номон дээр дүрсэлсэнтэй адил зүрх сэтгэлийн өөрчлөлт хэрэгтэй: “мөн тэд бүгд хүмүүст нэгэн адил зүйлийг тэдний зүрх сэтгэл өөрчлөгдсөнийг; тэд хиэнцийг үйлдэх хүсэлгүй болсныг тунхаглав” (Алма 19:33, мөн Мозая 5:2-ыг үзнэ үү).

Бид Их Эзэний сайн мэдээнд жинхэнэ хөрвөгдсөн бол мөнхийн амьдрал руу аялах явцад бидний зүрх сэтгэл хувийн ашиг сонирхлоосоо татгалзаж, бусдад туслах үйлчлэл рүү чиглэгдэн өөрчлөгдсөн байх болно гэж Тэрээр заасан байдаг. Тэрхүү хөрвөлтийг олж авахын тулд бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан шинэ хүн болохын тулд итгэлтэйгээр залбирч, ажиллах ёстой.

Бид хувиа хичээсэн байдлаа наманчлах, итгэл болон бусдад өөрсдөөсөө илүү санаа тавих бэлгийг авахын тулд залбирснаар эхэлж болно. Бид бардамнал, атаа жөтөөнөөс салах хүчийг олж авахын тулд залбирч болно.

Залбирал нь Бурханы үгсийг хайрлах хайрын бэлэг болон Христийн хайрыг хүлээн авах түлхүүр юм

(Моронай 7:47-48-ыг үзнэ үү). Энэхүү хоёр зүйл нь хамт ирдэг. Бид Бурханы үгсийг уншиж, тунгаан бодож, залбирснаар тэдгээрийг хайрладаг болно. Их Эзэн тэр хайрыг бидний зүрх сэтгэлд суулгаж өгдөг. Бид тэр хайрыг мэдэрснээр Их Эзэнийг илүү ихээр хайрлаж эхэлдэг. Үүнтэй хамт Бурхан бидэн рүү илгээсэн хүмүүсийг дэмжиж хүчирхэгжүүлэхэд шаардагдах бусдыг хайрлах хайр бас ирнэ.

Жишээ нь, бид Их Эзэн номлогчдоороо заалгуулахаар бэлтгэсэн хүмүүсийг олж танихын тулд залбирч болно. Бүрэн цагийн номлогчид юуг зааж, гэрчлэхээ Сүнсээр дамжуулан олж мэдэхийн тулд болон тэдний уулзсан хүн болгон Түүний хайрыг мэдрээсэй хэмээн Их Эзэнд итгэлтэйгээр залбирч болно. Номлогчид уулзсан бүх хүмүүстээ баптисм хүртээж, Ариун Сүнсний бэлэг өгч чадахгүй. Гэхдээ тэд Ариун Сүнсийг өөрсдийн хамтрагч болгож чадна. Өөрсдийн хийсэн үйлчлэлээр дамжуулж, мөн Ариун Сүнсний тусламжтайгаар номлогчдын сэтгэл зүрх аяндаа өөрчлөгдөнө.

Тэд болон бид бүхэн өөрсдийн амьдралын туршид Есүс Христийн сайн мэдээгээр бусдыг хүчирхэгжүүлэхийн тулд өөрийгөө умартан итгэлтэйгээр үйлдсэнээр тэрхүү өөрчлөлт үргэлж шинэчлэгдэж байх юм. Хөрвөлт нь ганц удаагийн тохиолдол эсвэл нэг улиралд болоод өнгөрөх зүйл биш харин үргэлжлэн явагдах үйл явц юм. Бид Аврагчийг харж, Түүнтэй адил болсноо олж мэдэх төгс өдрийг хүртэл амьдралаа илүү гэрэл гэгээтэй болох боломжтой. Их Эзэн энэ аяллыг ийнхүү дүрсэлсэн байдаг: “Бурханаас буй тэр нь гэрэл болой; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг” (С ба Г 50:24).

Бидний хүн нэг бүр үүнд хүрэх боломжтой болохыг би амлаж байна.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар “даршилсан өргөст хэмхийн сургаалт зүйрлэлийг” ашиглаж хөрвөлт нэг удаа болоод өнгөрдөг үйл явдал биш харин үргэлжлэн явагддаг үйл явц болохыг заасан. “Шат шатаар, дүрэм дүрмээр, бага багаар, бараг ажиглагдалгүйгээр бидний сэдэлт, бодол санаа, үгс болон үйлс Бурханы хүсэлтэй нэгдсэн байх болно,”

(“Та дахин төрөх ёстой”, *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 19). Зааж байгаа хүмүүстээ даршилсан өргөст хэмхийн сургаалт зүйрлэлийг хуваалцах талаар бод. Ерөнхийлөгч Айринг болон ахлагч Бэднар нарын ярьсан бага багаар явагдах хөрвөлтийн үйл явцад тууштай байхын тулд бид бүхэн юу хийж чадах вэ?

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД

Миний зүрх сэтгэлийн өөрчлөлт

Данте Байрадо

Би анх Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний тухай сурч байхдаа үүнийг үнэн зөв болохыг Сүнс гэрчлэхийг мэдэрсэн. Залбирснаар миний гэрчлэл улам бэхжиж би баптисм хүртэхээр шийдсэн.

Баптисм хүртсэний дараа нэг их удалгүй манай тойргийнхон номлолд үйлчлэх талаарх миний санал бодлыг асууж эхэлсэн. Үнэнийг хэлэхэд, би юу гэж хэлэхээ сайн мэдэхгүй байлаа. Гэр бүл болон сургуулиа орхиод номлолд үйлчилнэ гэдэг утгагүй зүйл мэт санагдаж байлаа.

Тэгээд нэгэн өдөр би өөрийн хөрвөлтийн талаар бодож эхэллээ. Би надад хичээл зааж, миний асуултад тэвчээртэйгээр хариулж, сайн мэдээг ойлгоход маань тусалсан номлогчдынхоо талаар бодлоо. Тэдний тусламжгүйгээр би хэзээ ч Сүмийн талаар олж мэдэхгүй байх байснаа ухаарлаа. Үүнийг ухаарч ойлгонгуут үйлчлэх хүсэл миний сэтгэлд урган дэлбээлсэн юм. Сүнс надад бүрэн цагийн номлолд үйлчлэх ёстой гэж хэлэхийг би мэдэрч байлаа.

Номлолын ажил нь бидний Тэнгэрлэг Эцэгийн ажил гэдгийг мөн бид сэргээгдсэн сайн мэдээний гайхалтай мэдлэгт бодгалуудыг авч ирэхэд тусалж чадна гэдгийг би мэднэ

Зохиогч нь Бразилийн Форталезад амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД

Өөрийнхөө гэрчлэлийг хурцаар гэрэлтүүл.

Гэрчлэлтэй болно гэдэг нь яг л гал асаахтай адил. Галыг унтраахгүйн тулд мод нэмэх хэрэгтэйн адил бид өөрсдийн гэрчлэлийг хурц байлгахын тулд залбирч, наманчилж, бусдад үйлчилж, судраас суралцаж мөн тушаалуудыг дагах ёстой.

Гэрчлэлээ хэрхэн хөгжүүлэх талаар илүү ихийг сурахын тулд дор жагсаасан судруудыг уншина уу. Галын таван том дөл зур. Судрыг унших болгондоо дөлийг буд. Судар уншихын хэрээр таны гал болон гэрчлэл хурцаар дүрэлзэн асах болно.

Мозая 2:17

Алма 5:46

Алма 32:27

3 Нифай 15:10

Иохан 5:39



Есүс Христийн зан чанар: Гэм нүгэлгүй

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд эрэлхийлж хай. Аврагчийн амьдрал ба үүргийг ойлгох нь Түүнд итгэх таны итгэлийг хэрхэн өсгөх мөн айлчлагч багшаар дамжуулан таны харж хандан, анхаарал тавьдаг хүмүүсийн амьдралыг адислах вэ? Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Итгэл, гэр бүл, халамж

Энэ бол Аврагчийн онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасын нэгэн хэсэг болно.

Бидний Аврагч Есүс Христ бол бүх хүн төрөлхтний төлөө цагаатгал хийж чадах цорын ганц хүн нь байв. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Дийтр Ф.Угдорф хэлэхдээ: “Ямар ч толбогүй Хурга болох Есүс Христ нь өөрийн сонголтоор, биеэ золиослолын тахилын ширээн дээр тавьж, бидний нүглийн төлөөсийг төлсөн билээ.”¹ Есүс Христ ямар ч нүгэлгүй байсныг ойлгох нь бидэнд Түүнд итгэх итгэлээ хөгжүүлж, Түүний тушаалуудыг дагаж, наманчилж, цэвэр ариун болох хүслийг маань нэмэгдүүлнэ.

“Есүс нь . . . бие махбод болон сүнснээс бүрдсэн хүн байсан ч уруу таталтанд автаагүй юм (Мозая 15:5-ийг үзнэ үү),” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон хэлсэн. “Тэр биднийг ойлгодог тул . . . бид Түүнд хандаж болно. Тэрээр зовлонг ойлгохоос гадна зовлонг хэрхэн даван гарахыг мөн ойлгодог. . . .

“ . . . Түүний Цагаатгалын хүч бидний нүглийн үр нөлөөг арилгаж чадна. Биднийг наманчлахад Түүний цагаатгагч ач ивээл нь биднийг зөвтгөж, ариутгаж байдаг (3 Нефай 27:16-20-ийг үзнэ үү).

Яг л бид хэзээ ч нүгэлд татагдаж, бууж өгөөгүй юм шиг болж чадна.

“Бид өдөр тутам, долоо хоног болгон Христийн замаар хичээнгүйлэн дагавал бидний сүнс үүний давуу байдлыг хүлээн зөвшөөрч, доторх мөргөлдөөн намжиж, уруу таталт зовоохоо больдог.”²

Нэмэлт судрууд

Матай 5:48; Иохан 8:7; Еврей 4:15; 2 Нифай 2:5–6

Судруудаас

Аврагч бидний нүглийн төлөөсийг Өөрийн бурханлиг Хүүгийн эрх, нүгэлгүй амьдрал, зовлон зүдгүүр мөн Гетсеманий Цэцэрлэгт Өөрийн цусыг урсган байж төлсөн юм. Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан нүглээ наманчилснаар бид цэвэр болох юм.

Бенжамин Хаан өөрийн хүмүүст Есүс Христийн Цагаатгалын

талаар заасныхаа дараа тэд түүний үгэнд итгэж байгаа эсэхийг асуудаг. “Мөн тэд бүгд нэгэн дуугаар хашгирч, өгүүлсэн нь: . . . Сүнс бидэнд хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх болгон, бидэнд, өөрөөр хэлбэл бидний зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлтийг үйлдсэн . . .

“Мөн бид . . . бүх зүйлд, түүний зарлигуудад дуулгавартай байж, Бурхантайгаа түүний тааллыг гүйцэлдүүлэх гэрээ хийхэд бэлэн байна” (Мозая 5:1-2, 5).

Бид ч мөн “хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгож, харин үргэлж сайныг хийх болгосон” Бенжамин хааны хүмүүсийн адил зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” мэдэрч чадна (Мозая 5:2).

Эшлэл

1. Дийтр Ф.Угдорф, “Та одоо босч чадна аа!” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 56.
2. Д.Тодд Кристоффэрсон, “Тэд бидэнтэй нэг байж болохын тулд,” *Лиакхона*, 2002 оны 11-р сар, 71.

Үүнийг эргэцүүлэн бод

Цэвэр ариун байх нь төгс байхаас юугаараа ялгаатай вэ?